

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.11.11

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын 47 дахь ерөнхийлөгчөөр Donald Trump сонгогдлоо.
- Donald Trump ерөнхийлөгч болж дайны эрсдэл буурсан тул алтны ханш уналаа.
- Тэг хувийн татвар болон 60%-ийн тарифаас шалтгаалж зах зээл өслөө.
- АНУ-ын ХНС хүүгээ 0.25%-иар буурууллаа.
- Хятадын эдийн засгийн удаашрал үргэлжилж байна.
- Энэ долоо хоногт АНУ болон БНХАУ-ын хэрэглээний үнийн индекс зарлагдана.

2024 он 11-р сарын 11

Dow Jones	43,988.99
S&P 500	5,995.54
Nasdaq	19,286.78
DAX	19,215.48
FTSE 100	8,072.39
S&P/ASX 200	8,249.60
HANG SENG	20,276.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.59%	5.25%	2.62%	16.71%	28.31%	21.85%
S&P 500	0.38%	4.95%	3.10%	25.70%	35.79%	28.03%
Nasdaq	0.09%	6.09%	5.15%	28.48%	39.78%	21.60%

2024 оны 11 сарын 11-ний 11:30

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-0.76%	0.35%	-0.82%	14.71%	26.13%	19.39%
FTSE 100	-0.84%	-1.37%	-2.20%	4.39%	9.67%	9.86%

2024 оны 11 сарын 11-ний 11:30

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-0.45%	1.13%	0.52%	8.78%	18.35%	10.94%
Hang Seng	-2.22%	-1.41%	-4.58%	18.95%	17.87%	-19.94%

2024 оны 11 сарын 11-ний 11:30

ЗӨВЛӨМЖ

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн эдийн засагт үзүүлэх нөлөө:

Импортын барааны өндөр тариф болон тэг хувийн татвараас шалтгаалан инфляц өсөх магадлалтай байна. БНХАУ-ын Ардын Их хурлын гаргасан бодлого шийдвэрээс шалтгаалан Хятадын хөрөнгийн зах зээлийн хувь заяа шийдэгдэнэ.



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Зах зээлийн хүчтэй өсөлт

АНУ-ын голлох гурван индекс бүх цаг үеийн дээд ханшаа шинэчлэн тогтоож, 7 хоногийн гүйцэтгэлээр NASDAQ 6.09%, S&P 500 4.95%, DJIA 5.25%-иар тус тус өсөөд байна. Мэдээж зах зээл дээр маш олон мэдээ мэдээллүүд зарлагдаж дэлхийн хөрөнгийн зах зээлийг хүчтэй хөдөлгөсөн чухал үйл явдлууд өрнөсөн.

АНУ-ын ерөнхийдөгчийн сонгууль ба эдийн засаг дахь нөлөө

47 дахь ерөнхийлөгчөөр Бүгд Найрамдах намаас нэр дэвшсэн Donald Trump тодорсноор хөрөнгийн зах зээлд эерэг нөлөөг үзүүллээ.

Түүний баримталж буй бодлогын хувьд:

- Орлогын албан татварыг 0% болгох
- Импортын барааны тарифыг 10% болгох тэр дундаа Хятадаас орж ирэх бүх бараанд 60% татвар ногдуулах
- Цагаачлалыг хязгаарлах

Мэдээж эдгээр бодлогоос шалтгаалж гаднаас орж ирэх бараа бүтээгдэхүүн хомсдож, дотоодын компаниудын тогтвортой өсөлтийг бий болгоно гэсэн хүлээлтийг үүсгэснээр хувьцааны ихэнх индексүүд өсөөд байна. Энэ байдал нь цаашлаад инфляцыг өдөөх хүчин зүйл болох эрсдэлтэй.

ХНС бодлогын хүүгээ бууруулав

ХНС бодлогын хүүгээ 0.25%-иар бууруулсан нь таамаглалын дагуу гарсан үзүүлэлт боллоо. Ингэснээр бодлогын хүүгийн 4.50-4.75%-ийн хооронд болгож, дараалан хоёр дахь удаагийн хүү бууруулах шийдвэр болоод байна. Мэдээж энэхүү шийдвэр нь тогтвортой үнийн түвшин болон бүрэн ажил эрхлэлтийг хадгалах зорилгын хүрээнд гаргаж байгаа бодлогын нэг юм.

Үүний зэрэгцээ ХНС-ийн тэргүүн Jerome Powell 2026 оны 5-р сард бүрэн эрхээ дуусгах бөгөөд шинээр ерөнхийлөгч болсон Trump түүний халааг солих шийдвэр гаргах юм. Мөн тэрээр “Хэрэв Ерөнхийлөгч Donald Trump түүнийг албан тушаалаас нь огцруулахыг оролдсон тохиолдолд “Үгүй” хэмээх хариултыг өгнө” гэжээ.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Өнгөрсөн долоо хоногт Хятадын хөрөнгийн зах зээл нь АНУ-ын сонгуулийн нөлөө, Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашрал, мөнгөний бодлого зэрэг хүчин зүйлс шалтгаалан уналаа. Хонконгийн "Hang Seng" индекс өнгөрсөн долоо хоногт 4%-иар буурч 17,000 орчимд хаагдсан. Харин шинжээчид энэ уналтыг түр хугацааны засварын хөдөлгөөн хэмээн таамаглаж байна.

Хятадын эдийн засгийн үзүүлэлтүүд

Хятадын эдийн засгийн өсөлт суларч, үйлдвэрлэлийн салбарын өсөлт удааширсан нь Хонконгийн хөрөнгийн зах зээлд сөрөг нөлөө үзүүлсэн. Зарим хэвлэлийн мэдээллүүдэд Хятадын дотоодын хэрэглээ, хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны өсөлт удааширч байгаа гэж дурдсан.

Мөнгөний бодлого

Төв банк мөнгөний бодлогыг сулруулж, зах зээлд хөрөнгө оруулалт нэмэгдүүлэхийг зорьсон. Гэсэн хэдий ч эдийн засгийн хэтийн төлөв тааруу байгаагаас шалтгаалан хөрөнгө оруулагчдын итгэл төдийлөн сэргээгүй.

Технологийн салбар

Хонконгийн технологийн хувьцаанууд томоохон алдагдал хүлээсэн. Тухайлбал, Alibaba, Tencent зэрэг том компаниудын хувьцааны үнэ 2-3 хувиар унасан байна. Үүний шалтгаан нь Хятадын технологийн салбарын зохицуулалтын орчин, бусад орнуудтай харьцах асуудлууд байна гэж үзэж байна.

Гадаад зах зээлүүдийн нөлөө

АНУ-ын төв банкны хүүгийн өөрчлөлт болон Европын эдийн засгийн өсөлт бага зэрэг удааширсан нь Америк болон Европын хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүдийг өөрчилсөн ч Хонконгийн зах зээлд хүчтэй нөлөө үзүүлсэнгүй.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал



ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning November 04, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
CEG Constellation	PLTR Palantir	MELCO MELCO	SMCI SUPERMICRO	CELH CELSIUS	ARM arm	VST VISTRA ENERGY	DING DRAFT KINGS	IEP IEP	
MAR Marriott International	HRS hims hers	ADM ADM	DEVN devon	NOVO novo nordisk	QCOM Qualcomm	MRNA moderna	ARMT ARISTA	ERJ EMBRAER	
BKRC Berkshire Hathaway	CLF CLIFFS	SNDL SUNDIAL	LUMN LUMEN	CVS CVS Health	AMC amc	GOLD BARRICK	BQ BLOCK	SONY SONY	
DOCN DigitalOcean	WYNN Wynn Resorts	FERR Ferrari	PAA PAN AMERICAN AIRWAYS	AUR AURORA	ELF elf	DDOG DATADOG	RIVN RIVIAN	GRG gray	
FRPT freshpet	NXP NXP	APLS Apellis	KINR KINROSS	HOWM HOWMET AEROSPACE	CLV Clover	HAL HALLIBURTON	UNITY unity	CGC CANOPY GROWTH	
BEN FRANKLIN TEMPLETON	LSCC LATTICE	APOL APOLLO	MCHP MICROCHIP	TEVA teva	APP APPROVIN	GEO The GEO Group, Inc.	TTD theTradeDesk	DIBS DIBS	
FIS FIS	AALB Asterand	GLF GlobalFoundries	CPNG coupan	TM TOYOTA	MELI mercado libre	HSY HERSHEY	AFRM affirm	BLOIN BLOOMING BRANDS	
YUMU YumChina	NAV Navitas	LP LP	BBIG BIGBEAR AI	FUN Six Flags Entertainment Corporation	COUE CORUS MINING	ESPR ESPERION	ABNB airbnb	ADNT ADIENT	
SLGT SELECTIQ	PGR PROGRESSIVE	BLDR Builders FirstSource	EXAS EXACT SCIENCES	MARK MarketAxess	HEI HEI	PNW PARNET	FBIN FORTINET	AXL AMERICAN AXE MANUFACTURING	
ZTS zoetis	AIG AIG	BGS B&G Foods, Inc.	BFG B&G Foods, Inc.	AEP AMERICAN ELECTRIC POWER	ALB ALBEMARLE	ACM ACM RESEARCH	PINS Pinterest	NRG nrg	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning November 11, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
MONY monday.com	ZETA ZETA	SHOP shopify	SOUN SoundHound	HUT HUT 8	NU nu	DIS Disney	AMAT APPLIED MATERIALS	BABA Alibaba Group	
ICL ICL	GRAB Grab	PLUG PLUG	MARA MARATHON	CYBR CYBERARK	CSCO cisco	INTU INTUITIVE MACHINES	ASTS AST SpaceMobile	AIM AIM Immunotech	
GLB GLOBAL SUPPLY	LUMN LUMINAR	CAVA CAVA	SPOT SPOTIFY	HIVE HIVE	d-local d-local	JD JD.COM	OKLO OKLO	SPECT Spectrum Brands	
ARAM aramark	ASST ASSERTICE	SEA sea	SPOT Spotify	SSYS stratus	BEAZ BEAZER HOMES	NICE NICE	DESP despegar	WISA wisa	
LINC LINCOLN TECH	AGG ASSURED GUARANTY	NOV novavax	OXY OXY	TSEM Tower Semiconductor	KULR KULR	BILI bilibili	GLOB Globant	HPH BioPath Holdings	
LIQD Liquidia	ANGI ANGI HOME SERVICES	NOV novavax	OXY OXY	PULX Pulcrum Therapeutics	OPTX OptimizeRx	ADV Advanced Auto Parts	POST PostNet	NEXN nexxen	
NUVE nuvellis	DOO DOUBLE DOWN	HRTZ Hertz	BHEM BioStem Technologies	ARCO Arcos Dorados	SMIC Summa Micro	SGOV SEW GOOD	ORIG ORIGIN		
RDNT RadNet	VX Veeva Systems	TLEN TALLEN ENERGY	ROCK ROCKET Companies, Inc.	BITD BITCOIN DEPOT	CPRI Capricor	BRKF Brookfield	PBEL Panbela		
ROCK ROCKWELL AUTOMATION	STXS STEREOTAXIS	BITF Bitfarms	WULF TERAVULF	PSFE Paysafe	BNGO bionano	NTEX NetEase Games	SBS sabesp		
SPNS SAPIENS	TALO TALOS	CRON CRONOS GROUP	CART instacart	INNO INNOVIZ TECHNOLOGIES	GORE GORE	OCUL Ocular Therapeutics	EMER emeren		